

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ АСУУДАЛ
ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Б.ЯНЖИНДУЛАМЫН 2024 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д 1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Үр дүнгийн үзүүлэлт				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрэх түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
ЗОРИЛТ НЭГ. “БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, ОРЧНЫ БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ, ДОРОЙТСОН ГАЗРЫГ НӨХӨН СЭРГЭЭХ, БАЙГАЛИЙН НӨӨЦИЙГ ЗОХИСТОЙ АШИГЛАХ НӨХЦЛИЙГ БҮРДҮҮЛЭХ”							
1	Арга хэмжээ 1.1 Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоолоор баталсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд мод тарьж арчилж, ургуулах ажлыг нарийвчилсан судалгаа, төлөвлөгөөний хүрээнд зохион байгуулж, мод тарих үйл ажиллагаанд хувийн хэвшил, иргэд, олон нийтийг оролцуулан мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх	-Тарьсан модны тоо, ургалтын хувь -Мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээлэл хүргэсэн байдал	12805 7 ширхэг	120000 ширхэг	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд сумын хэмжээнд төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний өдөр”-үүдээр сумын хэмжээнд нийт 14 аж ахуйн нэгж, байгууллага, 643 иргэн оролцож, 2,2 га талбайд 52000 ширхэг мод, бут сөөг тарьсан. Ойжуулалтад 231998	2024 оны 05,06, 10 сар	

					ширхэг шинэс модыг тарьж нийт 283998 ширхэг тарьсан. Цэцгийн мандлыг байгууллага бүр нийт 160 м2 талбайд тарьсан. Мод тарих үйл ажиллагаанд нийт 265,000,000 төгрөгийг зарцуулсан. Төв суурин газрын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор бүх нийтээр “Мод тарих үндэсний” өдрийг угтаж мод бут, сөөг тарьж ургуулах, ногоон байгууламжид тарьсан мод бутыг услах арчлах, хамгаалах, танаж хэлбэржүүлэх ажлыг зохион байгуулж, мод тарих аргачлал зөвлөмжийг 1500 иргэнд тарааж, facebook группээр сурталчилсан		
2	Арга хэмжээ 1.2 Ойн хортон хөнөөлт шавьжийн устгал тэмцлийн ажил гүйцэтгэх	Хортон устгал хийгдсэн талбайн хэмжээ	7407 га	Хортон устгал хийгдэх ой бүхий сумын судалгааг хавсралтаар	Худалдан авах ажиллагааны хүрээнд 3 компани оролцон “Гранд форест” ХХК нь 303 сая төгрөгний төсөвт өртөгөөр	2024 оны 12	

					гүйцэтгэн, ойн хортон хөнөөлт шавьжийн устгал тэмцлийн ажлыг үүргийн шүршигч ашиглан химийн аргаар 7875 га-д гүйцэтгэсэн. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, ЗГХА Ойн газар, Рио Тинто Монгол ХХК, “Олон улсын байгаль хамгаалах нийгэмлэг групп (ICCF Group)” хамтран хэрэгжүүлж буй “Эрүүл ой төсөл”-ийн санхүүжилт болон улсын төсвийн хөрөнгөөр Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 20,000 га талбайд агаарын хөлөгөөр ойн хөнөөлт шавжтай тэмцэх ажил гүйцэтгэж байна		
3	Арга хэмжээ 1.3 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын хэрэгжилт, мөн хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах	Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого-50 хувь Ойн нөөц ашигласны төлбөрийн	390 сая	30 арга хэмжээ 100 хувь	Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах,	2024 оны 12	

		орлого-85 хувь Ус рашаан ашигласны төлбөрийн орлого-55 хувь			тайлагнах журмын тухай” журмыг хэрэгжүүлж ажиллах чиглэл авч, журмын дагуу төсөв хуваарилалтыг 01.15-ны байдлаар байгаль орчин, аялал жуулчлалын яамны мэдээллийн сайтад оруулсан. Одоогийн байдлаар 1,184,523,000 сая төгрөгний зарцуулалт хийгдэн, 30 арга хэмжээг худалдан авах ажиллагааны тендер, худалдан авах ажиллагааг зарлан ажлын хэсгүүд байгуулагдан гүйцэтгэгдэж байна..		
4	Арга хэмжээ 1.4 Амьтны амьдрах орчныг сайжруулах, өсгөн үржүүлэх, нэн ховор, ховор амьтныг хамгаалах арга хэмжээг зохион байгуулах, биотехникийн арга хэмжээг авах	Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авсан байдал, үр дүн, давтамж, тоо хэмжээгээр	4 цэгт 25 боодо л өвс 10 шахм ал давс	34 цэгт 250 боодол өвс 50 шахмал давс	03 дугаар сарын 03 ны өдөр Дэлхийн зэрлэг ан амьтан, ургамал хамгааллын өдрийг тохиолдуулан Өвтийн давааны Оно, Мухар хустын Бургас, Нууцат, Бөхөн шарын Зүүн,Баруун байц, Урд Агуйтын Асгат, нарийн нүүр гэх газар зэрлэг ан амьтанд биотехникийн	2024 оны 12 сар	

					арга хэмжээ авч 250 боодол ногоон өвс, 250 кг буюу 50 шахмал давс, хужир нутгийн иргэд, байгаль хамгаалагч нартай хамтарч тавьсан. 2025 оны биотехникийн арга хэмжээний нарийн ногоон өвсийг 350 боодол авч нөөцөлсөн. Нийт 15 сая төгрөгөөр санхүүжилт хийсэн.		
5	Арга хэмжээ 1.5 Шонхор шувууг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх хүрээнд цахилгаан дамжуулах шугамын тулгуурын тусгаарлагчид болон хиймэл үүр хийх	Агнуурын бүс нутагт биотехникийн арга хэмжээ авсан байдал, үр дүн, давтамж, тоо хэмжээгээр	0	25 үүр	2 аж ахуйн нэгж, 5 нөхөрлөл нийт шувууны үүр 25 ширхэг хийж тавьсан. Шувууны үүр хэн сайн хийх вэ уралдаанд 1 аж ахуйн нэгж, 1 нөхөрлөл шалгарч шагналт байр эзэлсэн.	2024 оны 05 сар	
6	Арга хэмжээ 1.6 Сум хог хаягдлын менежментийг сайжруулах төлөвлөгөө боловсруулж, батлуулан, бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулах	Хэрэгжилтийн хувь Нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулсан тоо хэмжээ	4	6	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг өөрчлөн тогтоох шийдвэрт өөрчлөлт оруулахаар бичиг баримтыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн	2024 оны 12	


					боловсруулж, ИТХ-ын ажлын албанд хүргүүлсэн. Сумын хэмжээний хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулах худалдан авахаар тендер зарлан 3 байгууллагаас. “Өнгө нэм” ТББ шалгарч 20 сая төгрөгөөр гэрээ байгуулан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөгөө боловсруулан хүлээлгэн өгөхөд бэлэн болсон байна. Тайланг танилцуулах ажлыг 12 дугаар сарын 19 нд танилцуулна. “Бүх нийтийн хог цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай” 2024 оны А/76 дугаар захирамжийн дагуу 2024 оны 04 дүгээр сарын 25-27-ны хооронд хаврын бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулсан. Нийт 4 удаагийн хог		
--	--	--	--	--	---	--	--

					тархсан талбайг хумиж, отволдсон. 340000 м2 талбайн хог хаягдлыг цэвэрлэн 3654 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэн төвлөрсөн хогийн цэгт буулгав.		
7	Арга хэмжээ 1.7 Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах үйл ажиллагааг дэмжих, дахивар бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх боломжийг бүрдүүлэх	Хоёрдогч түүхий эд нягтруулж, пресслэх төхөөрөмжийн тоо -Ангилан ялгасан хог хаягдлын хэмжээгээр (хувиар)	2	3	Ангилан ялгах сав нийтийн эдэлбэр газруудад тавиж, албан байгууллага, аж ахуйн нэгж, иргэд үйл ажиллагаа явуулж буй цэгүүдэд байршуулсан. 2 цэгт пресслэгч машин тавьж ажиллуулж байна. Нийтийн эдэлбэрт газрын 12 цэгт ангилан ялгах хогийн савуудыг тавьсан. Хаягдал төмөр-40тн, хуванцар сав- 3 пресс буюу 10кг, пиво, ундааны хөнгөн цагаан лааз-8 пресс буюу 320 кг цуглуулан пресслэгч тоног төхөөрөмжөөр нягтруулан пресслэн зах зээлд борлуулсан.	2024 оны 12 сар	
8	Арга хэмжээ 1.8 Сумын төвд энгийн хатуу хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн хэмжээг багасгах	Сумын төвлөрсөн хогийн цэгийн	2023 онд хогийн	Хог хаягдлын төвлөрсөн цэгийн талбайн	Талбайн хэмжээг багасгахаар 4 удаагийн түрэлт хумих ажлыг хийж, 16 га талбайгаас	2024 он	

		хэмжээ багассан байна	цэгий н 16 га	хэмжээг багасгаж, тохижуулсан байна.	5 га багасгаж, 11 га болгосон. Хатуу хог хаягдал болох төмрөөс иргэд 5 удаа тээвэрлэлтээр 40 гаруй тн төмөрөөс 20 гаруй сая төгрөгний борлуулалт хийж, өөрсдийн орлогоо бүрдүүлсэн.		
9	Арга хэмжээ 1.9 Усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, үер усны аюулаас урьдчилан сэргийлэх, байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн арга хэмжээ, байгалийн нөөцин ашиглалт хамгаалалтын талаарх иргэд олон нийтийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааны ажил зохион байгуулах <i>Ногоол зуртны</i>	сургалт, сурталчилг ааны тоогоор	2	1	03 дугаар сарын 21,22 - нд Дэлхийн ой болон усны өдөрлөгийг зохион байгуулан Ерөнхий боловсролын сурагчдын дунд "АХА" тэмцээн зохион байгуулсан. "YOUTH POWER" байгальд ээлтэй залуусын чуулганыг санаачлан зохион байгуулж, үе тэнгийнхнээ манлайлан, эх дэлхийдээ өөрийн бодит хувь нэмрээ оруулан 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдөр чуулганыг зохион байгуулсан. Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын соёлын төв 90	2024 оны 12 сар	

					хүүхэд оролцсон. Нийт 9 асуудлыг хөндөж хэлэлцүүлэг зохион байгуулсан.		
10	Арга хэмжээ 1.10 Засгийн газрын 2019 оны 474 дүгээр тогтоолын хүрээнд хийгдсэн “Ундны усны чанарын судалгаа”-ны нэгдсэн дүгнэлт зөвлөмжийн дагуу сумд “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г боловсруулж, батлах	Ундны усны стандартад нийцсэн байна.	-	Ундны усны чанар сайжирсан байна.	“Усны аюулгүй байдлын төлөвлөгөө”-г аймгийн ИТХ-аар батлуулахад сумаас 2 саналыг оруулсан. Аймгийн “Усны аюулгүй байдлын төлөвлөгөө” батлагдсны дараагаар суманд төлөвлөгөөг батлагдах учир аймгийн төлөвлөгөө батлагдаагүй тул сумын төлөвлөгөө хойшлогдсон.	2024 оны 12 сар	
11	Арга хэмжээ 1.11 Сум булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалан, орон нутгийн өмчид бүртгэх	Ундны усны стандартад нийцсэн байна.	15	Нэн шаардлагатай 15 булаг шанд, ✓ рашааны эхийг хашиж хамгаалах	Бүртгэлд оруулж орон нутгийн өмчид бүртгүүлэх санал хүргэсэн. Өмчид авсан. Хүйтэн булгийг 12 сая төгрөг, Мойлтын булаг 4 сая төгрөгөөр хашиж хамгаалахаар гэрээ байгуулсан. Урьд онуудад хашигдсан 15 булаг өмчид бүртгүүлсэн.	2024 оны 12 сар	

12	Арга хэмжээ 1.12 Иргэд олноор хэрэглэдэг, эмчилгээний зориулалттай рашаан, рашаан төст булгийн эхийг тэмдэгжүүлэх	Нэн шаардлагат ай булаг шанд, рашааны эхийг хашиж хамгаалах	-	10	Хятруун, Могойт, Хуст, Үүртийн рашаануудын эхэнд тэмдэгжүүлэхээр саналаа аймгийн БОАЖГазарт хүргэсний дагуу 4 рашааны эхэд самбар байршуулсан. 12 тестээр 4 самбарт тэмдэглэгдэн орсон.	2024 оны 12 сар	
13	Арга хэмжээ 1.13 Сумын төвийн усан хангамжийн эрүүл ахуйн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын бүс тогтоож тэмдэгжүүлэх	Эхийг тэмдэгжүүлсэн рашаан, рашаан төст булгийн тоогоор		Хамгаалалтын бүс тогтоосон байна	Усан хангамжийн эрүүл ахуйн эх үүсвэрийн эрүүл ахуйн хамгаалалтын 4 цэгт 8 ширхэг самбарын тэмдэгжүүлэлт хийж, байршуулсан. Эрүүл ахуйн бүс, хамгаалалтын бүс зэргийг тусган оруулсан.	2024 оны 12 сар	
14	Арга хэмжээ 1.14 Орон нутгийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хүрээнд орчны бохирдол, хог хаягдлын нэгдсэн менежментийг хэрэгжүүлж ажиллах	Хамгаалалтын бүс тогтоосон эсэх		- Байгальд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх үр дүнтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	2024 оны 07 дугаар сарын 02, 03-нд аймгийн БОАЖГазрын мэргэжилтнүүд, байгаль хамгаалагч нар хамтран аялал жуулчлалын бааз, эко гэр ажиллуулдаг нийт 60 иргэнд аялал жуулчлалын үйлчилгээ үзүүлэх журам, стандартаар сургалт зохион байгуулсан.	2024 оны 07 сар	

					Оролцогчдод орчны бохирдол, хог хаягдлын менежментийн талаар Өнгө нэм НҮТББ-тай хамтарч сургалт зохион байгуулсан. Агаар бохирдолын эх үүсвэрийн тооллогыг айл өрхийн бүртгэлийг 3-15 квт-ийн хүчин чадалтай зуухны бүртгэлээр 675 айл гэрт, 420 өрх байшин, 15-100квт-ийн хүчин чадалтай нам даралтын зуух 45 айл өрх, объект, 100-4500 квт хүчин чадалтай уурын зуух 3 - ийг бүртгэн нэгтгэн явуулсан.		
15	Арга хэмжээ 1.15 “Сарлагийн баяр” аялал жуулчлалын эвент арга хэмжээг зохион байгуулах	Стандартын шаардлагад нийцсэн хог хаях цэг, ариун цэврийн байгууламжийг бий болгосон байдал	700	1000	Сарлагын баярыг 15 дах жилдээ 2024 оны 07 дугаар сарын 23 нд Өндөр хясаа гэх газарт 1 өдөр зохион байгуулсан. Нийт 1500 гаруй аялагчид оролцсон. Үүнээс 700 гадаад аялагч бусад дотоодын аялагч оролцсон	2024 оны 07 сарын 23	

16	Арга хэмжээ 1.16 “Ice festival” аялал жуулчлалын өвлийн эвент арга хэмжээг зохион байгуулах	Жуулчдын тоо	300	0	2024 оны “Ice festival” аялал жуулчлалын өвлийн эвент арга хэмжээг 12 дах удаа хийхээр 12 дугаар сарын 07-08-ны хооронд Улаан цутгалан дээр 5 баг 3 төрлөөр уралдаан зохион байгуулагдан, мөсөн хананд авиралтын тэмцээнд 1 эрэгтэй 1 эмэгтэй тамирчид шалгарч, мөн гадаадаас Франц, Хятад улсын тамирчин оролцсон онцлогтой арга хэмжээ болсон.	2024 оны 12 сарын 06	
ЗОРИЛТ ХОЁР. “БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ЭРХ, ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ”							
20	Арга хэмжээ 2.1 Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан дүрэм журмыг чанд сахин биелүүлэх	Тухай бүр гарсан шийдвэрийн тоогоор биелэлтийг тооцох	1	Хууль тогтоомжид заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан байна.	2024 онд ойгоос “Бэлтгэх модны тоо хэмжээ тогтоох тухай” Өвөрхангай аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 23/06 дугаар тогтоол, Бат-Өлзий сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 07 өдрийн 17/04	2024 он	

					дүгээр тогтоолоор 2024 оны 11 сарын байдлаар сумын хэмжээнд 9 ойн мэргэжлийн байгууллага, 11 ойн нөхөрлөлтэй гэрээ байгуулж, 82 га талбайд 2274.1 м3 хэрэглээ, 8381м3 түлээ бэлтгэн орон нутгийн төсөвт 61,782,775 төгрөг төвлөрүүлж ажилласан. Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн “Хуш модны самар бэлтгэх хэмжээ тогтоох тухай” А/723 дугаар тушаалаар Өвөрхангай аймгийн Бат-Өлзий суманд 2024 онд 493 200 кг самрын зөвшөөрөл олгох,” Үйлдвэрлэлийн зориулалтаар бэлтгэх дуудлага худалдааг Бат-Өлзий суманд 8 багц болгон зарлаж, 5 Аж ахуйн нэгж шалгарч гэрээ байгуулан		
--	--	--	--	--	--	--	--

					одоогийн байдлаар 356920кг тээвэрлэгдэн 501 288 000 төгрөг төсөвт орсон.		
21	Арга хэмжээ 2.2 Хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хяналт шалгалт хийж, зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулах.	Хяналт шалгалтын зөрчлийн тоогоор	9	Хяналт шалгалт хуулийн дагуу хийгдсэн байна	Улсын ерөнхий прокурорын 2021 оны хавсралтын дагуу зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн хэлбэрийн жагсаалт, загварын дагуу зөрчилд дугаар авах, хялбаршуулан шийдвэрлэх журмаар зөрчлийн хэрэг бүртгэлийг хийж, прокурорын хяналтанд цаг хугацаанд гарган явуулсан. Нийт байгаль орчны чиглэлээр гомдол мэдээллийн дугаар 9 удаа, 1 гэмт хэргийн шилжүүлсэн, 5 гомдол мэдээллийн хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэн торгуулийн 1 700 000 төгрөг төсөвт оруулан шийдвэрлэсэн. Барагдуулалт 100%	2024 он	
22	Арга хэмжээ 2.3 Хяналт шалгалтад шаардлагатай сорьц,	Зохих дүгнэлтийг	1	Тухай бүрт	Сум дундын ойн ангийн дүгнэлтүүдийг үндэслэн	2024 он	

	дээжийг шинжлүүлж холбогдох газраар дүгнэлт гаргуулах арга хэмжээ авах	үндэслэн акт гарсан байна.			улсын байцаагчийн актаар 9 иргэнд 25 058 358 төгрөгний нөхөн төлбөр ногдуулан 23 418 358 барагдуулсан. 1 иргэний нөхөн төлбөр болох 1 640 000 төгрөг барагдаагүйг Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд шилжүүлсэн.		
23	Арга хэмжээ 2.4 Байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, хяналт тавих үйл ажиллагаанд иргэдийг татан оролцуулах, тэдний идэвх санаачилгыг өрнүүлэх, зөвлөн туслах ажлыг зохион байгуулах, хамтран ажиллах	1 сургалт, тэмцээн зохион байгуулагдсан байх	1	2 сургалт	Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд хангайн бүсийн сумдын ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл, байгаль орчны хяналтын, улсын байцаагч, байгаль хамгаалагч, аймгийн Цагдаагийн газрын экологийн асуудал хариуцсан ахлах мөрдөгч, сумдын экологийн асуудал хариуцсан байцаагч ойн салбарын холбогдох албан тушаалтнууд нийт 100 гаруй төлөөлөгч оролцсон сургалт, зөвлөгөөнийг 2024 оны	2024 оны 12 сар	

					3 дугаар сарын 28-29ний өдрүүдэд суманд болсон. Аялал жуулчлал эрхлэгчдийн зөвлөгөөнийг сумандаа зохион байгуулж, нийт 130 гаруй иргэд оролцсон.		
24	Арга хэмжээ 2.5 Хууль тогтоомж, стандарт зөвшөөрөгдөх хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүүлсэн иргэн, аж ахуйн нэгжийг уг зөрчил арилгахыг шаардах, зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг зогсоох	Хуулийн дагуу зөрчлийн баримт бичгийг хугацаандаа хүргэх	0	Хууль тогтоомж, стандартыг иргэн, хуулийн этгээдэд мөрдүүлсэн байна.	Хуулийн хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна. 2024 оны 11 дүгээр сарын 20-ны байдлаар иргэдэд 950 ширхэг эрхийн бичиг, гадагш тээвэрлэлтэд 750 ш гарал үүслийн бичиг олгож, хяналт тавин ажилласан. Хуулийн хэрэгжилтийн уул уурхайн 1, дэд бүтцийн 3, үйлчилгээний 3 төслүүдэд хяналт тавин ажилласан.	2024 оны 12 сар	

25	Арга хэмжээ 2.6 Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг биелүүлэх.	Ёс зүйн зөрчил гаргахгүй байна.	0	Ёс зүйн хэм хэмжээг сахиж удирдлагаас өгсөн хууль ёсны үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь биелүүлж ажиллах.	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг тухай бүрт гарган өгч ажилласан. Ёс зүйн зөрчил гаргаагүй	2024 он	
26	Арга хэмжээ 2.7 Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтийг бүрэн хариуцаж, зөрчил дутагдал гарсан тохиолдолд хариуцлага хүлээх	Жилд зөрчил дутагдал гаргаагүй байна.	0	Зөрчил дутагдалгүй ажилласан байна.	Эрхэлсэн ажлын чиг үүргийн хэрэгжилтэд зөрчил дутагдал гаргаагүй.	2024 он	
27	Арга хэмжээ 2.8 Сард хийсэн ажлын жагсаалтыг сар бүрийн 25-ны дотор гаргаж ЗДТГ-ын даргад хүргүүлэх	Эхний 11 сарын тайланг тайлагнасан байна	12	Зөрчил дутагдалгүй ажилласан байна.	12 сарын тайлан мэдээг хугацаанд өгч ажилласан.	2024 он	

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэн, хүний нөөцийг чадавхжуулж, төрийн	Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах		Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр	Бат-Өлзий сумын Засаг даргын Тамгын газрын даргын 2024 оны 08 дугаар сарын 02-ны өдрийн А/17 тоот		

	албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох (Төрийн албаны тухай хуулийн 55.3	нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр ийг хэрэгжүүлсэн байдал		дүн, мэргэшлийн түвшинг Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн 100 дугаар тушаалын 9 дүгээр хавсралт, 2023 оны 98 дугаар тушаалын 7 дугаар хавсралтаар батлагдсан аргачлалын дагуу үнэлж, дүгнэсэн байна.	тушаалаар Ёс зүйн дэд хороог байгуулсан. Ёс зүйн дэд хороо нь жилийн эцсээр байдлаар 3 судалгаа, 2 мэдээ, 1 тайланг холбогдох газарт хүргүүлсэн. Төрийн байгууллагад нийтдээ 5 зөрчил илэрснийг хэрхэн шийдвэрлэсэн талаарх мэдээллийг авч аймгийн Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн.		
2.	Арга хэмжээ 3.1. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг сурталчлан таниулах, сургалт хийх ёс зүйн дэд хороог байгуулах ажлыг сумын хэмжээнд зохион		-Төрийн албан хаагчийн ёс зүйн		Төрийн байгууллагуудын Ёс зүйн дэд хорооны дарга болон гишүүдэд Төрийн албан хаагчийн		

	байгуулах, мэргэшил арга зүйгээр хангах		тухай хуулийг сурталчлан таниулах талаар зохион байгуулсан сургалтын тоо		ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн талаар танилцуулж мэдээлэл өгсөн. Сургалтад байгууллагуудын Ёс зүйн дэд хорооны 14 гишүүн хамрагдлаа. Байгууллагынхаа албан хаагчдад Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн талаар талаар сургалт зохион байгуулж байгууллагын 23 албан хаагч хамрагдлаа.		
--	---	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт


Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7

1.	Арга хэмжээ 1.1 Хувь хүний өөрийгөө хөгжүүлэх манлайлалд суралцаж, шинэ мэдлэг мэдээллийг эзэмшсэн байна.	Сертифи каттай болох	1	2 сургалт	Мэргэжлийн чиглэлээр зохион байгуулагдаж буй улс бүс, орон нутгийн сургалтад танхимаар 6, цахимаар 4 удаа тус тус оролцсон. “Хангайн бүсийн хог хаягдал, хөрсний бохидлыг бууруулах чиглэлээр байгаль орчинд ээлтэй дэвшилтэт техник технологийг нэвтрүүлэх сургалтанд хамрагдаж сертификат авсан.	2024 оны 01 сар	
2.	Арга хэмжээ 1.1 ТАЗөвлөлөөс зохион байгуулж байгаа цахим сургалтад цахимаар суралцах	1	1	1 гэрчилгээ	Төрийн албаны зөвлөлөөс зохион байгуулж буй 4x7x10 сургалтанд 6 удаа ZOOM – ээр орсон. Залуучууд болон шинээр орсон албан хаагчдаа заавар зөвлөгөө өгч, зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн.	2024 оны 05 сар	
3.	Арга хэмжээ 1.1 Төрийн албаны тухай хууль, Байгаль орчны тухай хууль, дагалдан гарсан журам, заавар, зөвлөмжийг судлах	2	1	Албан үүргээ төрийн албаны хууль, журмын	“Сургагч багш бэлтгэх” сэдэвт богино хугацааны 16 цагийн цахим, онлайн	2024 оны 12 сар	

				дагуу гүйцэтгэх	дадлагын хосолсон сургалтанд хамрагдан 48 цагийн кредиттэй сертификат авсан.		
4.	Арга хэмжээ 1.1 Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Төрийн хяналтын тухай хуулийг судлах	3	2	3 хууль судлах	Хуулийн холбогдох заалт, холбогдох журмыг судлан ажил үүрэгтэй хэрэгжүүлэн 3 хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	2024 он	
5.	Арга хэмжээ 1.5 Монгол бичгээр уншиж, бичиж сурах	1	0	1	Өөрийн боломжоороо суралцаж байна. Уншиж бичиж чадна.	2024 он	
6.	Арга хэмжээ 1.6 Ил тод байдлыг ханган холбогдох материалыг цахим болон мэдээллийн самбарт байршуулах	1	2	1	Ил тод байдлыг ханган холбогдох материалыг цахимаар 5 болон мэдээллийн ананос самбар 10 байрлуулсан.	2024 он	
7.	Арга хэмжээ 1.7 Сумын түүхт жилийн ой зохион байгуулалттай ажлуудад тасралтгүй оролцож, шинэ санаачлага гаргаж ажиллах	0	0	1	Сумын түүхт жилийн ой зохион байгуулалттай ажлуудад ажил мэргэжлийн хувиар цэцэгжүүлэх ажлыг эхлүүлэн 12 модон хайрцаг бэлтгэн 5000 ширхэг мандлын цэцгийн суулгасан.	2024 он	
8.	Арга хэмжээ 1.8 Худалдан авах ажиллагааны сургалтанд хамрагдах	1	0	0	Одоогоор оролцоогүй байна. Шууд худалдан авалтын ахласан 5,	2024 он	

					оролцсон 3 арга хэмжээг зохион байгуулсан. Худалдан авах АЗ суртгалтад хамрагдсан.		
--	--	--	--	--	--	--	--

ТАЙЛАН ГАРГАСАН:
БОХ-ын улсын байцаагч
(Албан тушаал)



..... / Б.Янжиндулам / 2024 1204.....
(Нэр, гарын үсэг) (Огноо)